

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, "МОНГОЛБОЛГАРГЕО" ХХК  
НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН "БАЯНХОНГОР АЙМАГТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ГЭРЭЭ"-НИЙ  
2024 ОНЫ 2024/88 ДУГААР ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2025 оны 03 дугаар сарын 10

Сүмбэр

№	Гэрээний тусгай нөхцөл	Хэрэгжилт	Үнэлгээ /Хувиар/
1	2	3	4
1	3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бус эсхүл үндэслэлгүй эсхүл шударга бус байдлаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж Компанид нааштайгаар шийдвэрлүүлэх;	Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн төрийн байгууллагууд, иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бус саад учруулсан тохиолдол гараагүй болно.	100%
2	3.1.2. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр Хөдөлмөр халамж үйлчилгээний газраар дамжуулан эсвэл олон нийтийн хэрэгсэл болон цахимаар нийтэд зарлах	Тус компаний ажилчдын 90 хувь нь орон нутгийн иргэд байдаг. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг байнга дэмжиж ажилладаг. 2024 онд ажиллах хүчний хомсдол их байсан. Ковш, эксковаторын операторчны ажлын байранд мэргэжлийн ажиллах хүчин шаардлагатай байгааг Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт уламжилсан. Сумын Засаг даргын Тамгын газартай хамтран Галуут, Баян-Овоо, Эрдэнэцогт, Жаргалант сумын нутгийн 8 иргэнийг туслах ажилтанаар авч ажиллуулсан.	100%
3	3.1.3. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, орон нутгийн иргэдийг хамруулан дадлагажуулж ажилд авдаг.	70%
4	3.1.4. Ажиллах хүчнийхээ 50-иас доошгүй хувийг орон нутгаас ажиллуулах, Хөдөлмөр халамж үйлчилгээний	Манай компани нийт 50 ажилтантай. 46 нь Баянхонгор аймгийн иргэд ажилладаг. 2024 онд шинээр Галуут	100%

	газрын мэдээллийн санд бүртгэлтэй иргэдээс ажилд авах	сумын 8 иргэнийг авч ажиллуулж дадлагажуулан ажилласан.	
5	3.1.5. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх	Тус уурхайн Галуут сумын Сүмбэрийн 2дугаар багт байрладаг.2024 онд үйл ажиллагааныхаа талаар орон нутгийн иргэдэд сурталчлан мэдээлэл солилцон ажилласан. Нутгийн иргэдээс тавьсан санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажилласан.	70%
6	3.1.6.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг биелүүлж ажиллах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тусгагдсан ажлуудыг биелүүлэн ажиллаж байна. ТЭЗҮ, БОНБНҮ, уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна.	100%
7	3.1.7.Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэх;	Биологийн нөхөн сэргээлтийг 0,2 га-д, техникийн нөхөн сэргээлтийг дотоод овоолгоор 2,7га -д хийсэн. Дүйцүүлэн хамгаалалын хүрээнд Бөмбөгөр сумын нутаг Оргих-д 5,47 га талбайд нөхөн сэргээлт хийсэн.	100%
8	3.1.8.Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;	Үйл ажиллагааны зардлаар уурхай орчмын зам талбайг мал амьтан унаж бэртэхээс хамгаалж засаж сайжруулсан.	100%
9	3.1.9.Гурван талууд бүгд зөвшөөрсөн тохиолдолд зохион байгуулалтад орсон бичил уурхайн нөхөрлөлүүдтэй гурвалсан гэрээний үндсэн дээр талбай олгох, хамтран ажиллах; /Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батласан "Бичил	Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батласан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 4.3 дэх заалтын дагуу Галуут сумын "Баянхангайн түмэн хишиг" зэрэг 4 нөхөрлөлтэй	100%

	уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 4.3 дэх заалт/	гурвалсан гэрээ байгуулж ажилласан.	
10	3.1.10.Эрх бүхий байгууллага албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллах	Хууль журмын дагуу үйл ажиллагааг хэвийн явуулдаг.	100%
11	3.1.11.Уул уурхайн ил тод байдлыг бий болгож, олборлосон баялаг, татвар төлбөрөө тайлагнаж байх;	АМГТГ-т хууль заасан хугацаанд нь ил тодын тайлангаа тайлагнаж хэвшсэн. Холбогдох орон нутгийн татвар шимтгэлүүдийг төлдөг. Газрын төлбөр - 20.100.000төг, Хог хаягдлын төлбөр 1.800.000төг, аюултай хог хаягдлын төлбөр- 225.000, Ус ашигласны төлбөр -56.870.000 -ийг орон нутгийн дансанд төвлөрүүлж гэрээний үүргээ биелүүлж ажилласан.	100%
12	3.1.12.Олборлосон металлыг Баруун бүсийн үнэт металлын сорьц тогтоох лабораториор баталгаажуулж, Монгол банк болон эрх бүхий арилжааны банканд тушааж байх	Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн газрын үнэт метээллын газарт сорьцыг тогтоолгож ХААН банкинд тушаасан.	100%
13	3.1.13.Уурхай эрхлэхэд шаардагдах Ашигт малтмалын тухай хуулийн 35.3-р зүйлд заасан бичиг баримтын бүрдлийг бүрэн хангасан тохиолдолд ажлаа эхэлж байх;	Бичиг баримтын бүрдүүлэлтийг бүрэн болгож үйл ажиллагаагаа эхлүүлж холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна.Уурхай дээр байх бичиг баримтын бүрдлийг хангаж ажилласан.	100%
14	3.1.14.Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд аймаг, сумын өмнө тулгамдаж байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар санал санаачилга гаргах;	Ламын гэгээн Данзанжанцангийн мэлмий гийсний 385 жилийн ойн урлаг соёлын арга хэмжээнд 200,0сая төгрөгний тусламж дэмжлэгийг үзүүлсэн. Баянхонгор аймгийн ахлах Здугаар сургуулийг 5,000,000төг иж бүрэн цахилгаан хөгжимийг хандивласан.	100%
15	3.1.15.Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг гаднаас буюу бусад зах зээлээс авахгүй байх, орон	Дээжний уутыг Галуут сумын иргэн Бадмаас худалдан авсан.	100%

	нутгийн тухайлсан ААН-тэй гэрээ байгуулах;		
16	3.1.15.1.Мах, сүү, хүнсний ногоог 100% тухайн орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан худалдан авах;	Уурхай орчмын малчдаас мах, сүү цагаан идээг нь авч ажилчдыг эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсээр хангадаг.	100%
17	3.1.15.2.Ажлын хувцас, дээжний уутыг тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан худалдан авах;	Дээжний уутыг Галуут сумын иргэн Бадмаас худалдан авсан.	100%
18	3.1.15.3.Харуул хамгаалалтыг сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид давуу эрх олгох;	Баянхонгор аймгийн "Мөнхболд жигүүр"ХХК-ий Шонхор хамгаалалтын албатай гэрээ байгуулан ажилладаг.	100%
19	3.1.16.Аж ахуйн үйл ажиллагааны ашгаас авах татвараас бусад татвар шимтгэлүүдийг орон нутгийн төсөвт төлдөг байх;	Холбогдох орон нутгийн татвар шимтгэлүүдийг төлдөг. Газрын төлбөр -20.100.000төг, Хог хаягдлын төлбөр 1.800.000төг, аюултай хог хаягдлын төлбөр- 225.000, Ус ашигласны төлбөр -56.870.000 -ийг орон нутгийн дансанд төвлөрүүлж гэрээний үүргээ биелүүлж ажилласан.	100%
20	3.1.17.Ус ашигласны төлбөрийг тоолуураар хуулийн хугацаанд нь төлнө. Хэрвээ усны тоолуур суурилуулаагүй бол Эрх бүхий байгууллагаас баталсан дүгнэлтийг үндэслэн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаатай ноогдуулалтын гэрээ хийж, төлбөрийг орон нутагт тушаана. Ус ашигласны төлбөрийг дүгнэлтээр төлөх тохиолдолд 50-иас доошгүй хувийг ажил эхлэхэд Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна	Усны тоолуурыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар тавиулж баталгаажуулан ажилласан.Усны газрын гаргасан ус ашиглах дүгнэлтийн дагуу 56,870,000төгрөгний төлбөрийг 10дугаар сарын 06 нд орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлсэн.Улсын төсвийн хөрөнгөөр ус хайгуулын хийсэн зардлыг нөхөн төлүүлэх гэрээнд өөрчлөлт оруулан дахин тогтоолгож үлдэгдэл зардлыг 5 жилийн хугацаанд төлөх графикайн дагуу жилийн төлбөр болох 22,3сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.	100%

21	3.1.18.Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх;	Усны газрын гаргасан ус ашиглах дүгнэлтийн дагуу 56,870,000төгрөгний ус ашигласны төлбөрийг 10дугаар сарын 06 нд орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлсэн болно.	100%
<b>Гэрээний хэрэгжилтийн дундаж хувь:</b>			97%

ХЯНАСАН:  
 БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ  
 ДАРГА:  Д.МӨНХСАЙХАН

ДҮГНЭСЭН  
 ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
 ХЭЛТСИЙН ДАРГА:  Т.ЭНХБАЯР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
 "МОНГОЛБОЛГАРГЕО" УХК-ИЙ МЕНЕЖЕР  Г.ЖАВХЛАН

0324020016  
 ТУ34247 9007342